



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан¹)

ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ЗЭЭЛ ОЛГОХДОО ЗЭЭЛИЙН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭГ БОДИТ ЗАРДАЛД НИЙЦСЭН, ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ТОГТООХ ЁСТОЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2022/01092

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 11 сарын 11-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч Г.А нь хариуцагч “ГБ” ХХК-тай 2017.03.10-ны өдөр ЗГ1415112089 тоот зээлийн гэрээ байгуулж 55,900,000 төгрөгийг, хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар жилийн 27,6 хувийн хүүтэй, 60 сарын хугацаатай зээл олгох, үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд үндсэн хүүгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдүүлсэн хүү тооцохоор, мөн зээлийн гэрээний 2.1.6-д “Зээлийн хяналт, эрсдэлийн менежментийн шимтгэлд нэг удаа: зээлийн үнийн дүнгийн 1 хувь”; 2.7-д “Энэ гэрээний 2.1.6-д заасан зээлийн хяналт, эрсдэлийн менежментийн шимтгэлийг банканд төлөхийг зээлдэгч зөвшөөрсөн тул уг шимтгэлийг нэг удаа авна” гэж тохиролцжээ.

Улмаар нэхэмжлэгч Г.А нь хариуцагч “ГБ” ХХК-г зээл олгохдоо зээлийн үнийн дүнгийн 1 хувийг буюу 559,000 төгрөгийн зээлийн шимтгэлийг суутгах эрхийг өөртөө олгосон зээлдэгчид илт хохиролтой, хууль зөрчсөн нөхцөлийг гэрээнд тусгаж дээрх мөнгийг зээлийн дүнгээс суутгаж авсан. Иймд, зээлийн гэрээний 2.1.6-д заасны дагуу зээлийн үнийн дүнгийн 1 хувь болох 559,000 төгрөгийг шимтгэл нэрээр буцаан суутган хасч, санаатайгаар зээлийг дутуу олгож, зээлийг бүрэн бүтэн олгох гэрээний үүргээ зөрчсөн гэж үзэж, дутуу олгосон үнийн дүнг шаардсан.

Хариуцагч “ГБ” ХХК-аас Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дахь хэсэгт заасны дагуу зээлдүүлэгч зээл олгох нөхцөл болзлыг хуулийн дагуу тогтоох ба зээлийн харилцаанд оролцогч талууд харилцан

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/9951?daterange=2022-01-01%20-%202023-05-05&id=3&court_cat=1&bb=1



тохиролцсоны үндсэн дээр зээл олгох үйл ажиллагаа хийгддэг. Өөрөөр хэлбэл, банкны зээлийн шимтгэл нь нэг удаагийн шинжтэй, нийтэд урьдчилан мэдээлсэн байдаг. Тиймээс гэрээний 2.1.6, 2.7 дах хэсэгт “шимтгэл”-ийн талаар талууд тохиролцож, гарын үсэг зурж, нэхэмжлэгч Г.А зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү төлөхийг хүлээн зөвшөөрсөн гэж нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч маргасан.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүх:** “...зээлийн үнийн дүнгийн 1 хувиар шимтгэл авах эрхийг өөртөө олгосон нь зээлдэгчид илт хохиролтой, ...зээлдэгчийн зөвшөөрөлгүйгээр зээлээс суутгаж, зээлийг дутуу олгосон, ...банк Иргэний хуулийн 454 дүгээр зүйлийн 454.1², Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 22.1³ дэх хэсгийг зөрчсөн, ...бодит байдалд 1 хувийн зардал гараагүй, учир нь банкны зүгээс хяналт хийсэн, эрсдэлийн менежмент тооцсон ямар нэгэн ажиллагаа огт явуулаагүй, ийм зардал ч гараагүй...” гэж үзэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. (9)⁴
- 2. Давж заалдах шатны шүүх:** “...зээл олгосон шимтгэл буюу зээлдүүлэгчийг өөрийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хяналт, эрсдэлийн менежментийн төлбөрийг зээлдүүлэгчээс авах эрхийг хуулиар банкинд олгоогүй. Хариу төлбөртэй буюу хүү тогтоосон зээлийн гэрээний төлбөр дээр нэмж өөр хураамж, шимтгэл авахаар тогтоосон гэрээний уг заалт нь Иргэний хуулийн 202 дугаар зүйлийн 202.2.5-д зааснаар хүчин төгөлдөр бус..., иймээс зээлийн гэрээний шимтгэл 559,000 төгрөгийг буцаан гаргуулах нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэх нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1⁵, 56.5⁶ дахь хэсэгт нийцнэ...” хэмээн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн. (13)
- 3. Хяналтын шатны шүүх:** “...зээлийн хүү нь зээлийн үнэ буюу мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө тогтоосон хариу төлбөр тул зээлийн хүүд зарим үйл ажиллагааны зардал болох шимтгэл, хураамж багтдаггүй, ийм ч учраас зээлийн бодит өртгийг тодорхойлоход зээлийн хүүгээс гадна шимтгэл, хураамж, бусад зардлыг тооцож, тогтоох үндэслэлийг дурдсан журамд ч заасан. Иймд шимтгэлийг хариу төлбөр буюу зээлийн хүүд тооцогдоно гэж үзсэн давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлгүй болсон.” (14.2)
- 4. Зээлийн шимтгэлийн хэмжээ нь банкнаас тогтоосон, харилцагчаар төлүүлж буй үнийн дүнгийн тодорхой хувиар илэрхийлэгдэх бөгөөд зээлийн бодит өртгийн нэг**

² Иргэний хуулийн 454 дүгээр зүйлийн 454.1-д “Мөнгөн хадгаламжийн гэрээгээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь хадгалуулагчийн мөнгийг хадгалах, хадгалуулсан мөнгийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг хүлээнэ.”

³ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Зээлдүүлэгч нь олгосон зээл бүрдээ зээлийн хувийн хэрэг нээж хөтөлнө.”

⁴ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

⁵ Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д “Хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл.”

⁶ Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Энэ хуулийн 56.1-д заасан хэлцэл хийсэн талууд нь уг хэлцлээр шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй.”



- бүрэлдэхүүн болдог тул хуульд заагаагүй ч эдийн засгийн утгаараа зээлийн гэрээний харилцаан дахь зардлын нэг хэсэг нь болно. Иймд зээлийн шимтгэл тогтоохыг хуулиар хориглоогүй, ийнхүү хориглоогүй учраас зээлийн гэрээнд талууд шимтгэл тохирч байсан нь Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 13.2⁷, 189 дүгээр зүйлийн 189.1⁸ дэх хэсгийг зөрчөөгүй. Энэ үүднээс “зээлийн шимтгэлийг зээлдүүлэгчээс авах эрхийг хуулиар банкинд олгоогүй” гэх давж заалдах шатны шүүхийн дүгнэлт хуулийн дээрх зохицуулалтад нийцээгүй гэж үзнэ.(14.3)
5. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008.10.17-ны өдрийн 446 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан, тус журмын 9 дүгээр зүйлийн 9.1⁹-д **зээлийн шимтгэлийн харилцаа зохицуулагдаж, шимтгэлийн дээд хязгаарыг тогтоосон**. Улмаар 2021 онд Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлд шимтгэл тооцох харилцааг хуульчилсан байна.(14.4)
6. Тийм боловч нэхэмжлэгчийн зүгээс шимтгэлийг 1 хувиар тогтоосон нь үндэслэлтэй эсэхийг нотлоогүй. Энэ талаар “Шүүхийн практик, судалгаа, Монголбанкаас гаргасан “Зээл” гарын авлага, Монголын банкны холбооны Ерөнхийлөгчийн мэдээлэл зэрэг эх сурвалжаас үзвэл зээлийн шимтгэлийн хэмжээг 0,5-1 хувь, банкуудын хэрэглээний зээлийн дундаж шимтгэл 0,75 хувь, зарим банк бус санхүүгийн байгууллагаас 0.2 хувийн шимтгэл тогтоосон байх ба шүүхийн практикт “зээлийн шимтгэлд суутгасан 1 хувийг буцаан гаргуулах” нэхэмжлэлийг хангаж эсвэл нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж иржээ. Зээлийн шимтгэлийн хэмжээ нь гагцхүү бодит зардалд нийцсэн байх ёстой.”(14.7)
7. Хэргийн үйл баримтаас үзэхэд мөн хариуцагчийг “...зээлийн шимтгэлийг тогтооход зээлийн бүтээгдэхүүний төрөл, онцлогоос шалтгаалж тодорхой шалгуур үзүүлэлтийг баримталсан, бодит зардалд нийцсэн, Монголбанкнаас баталсан журмын дагуу энэ талаарх мэдээллийг хүргүүлсэн, холбогдох аргачлалыг нийтэд ил тодорхой байлгах, мэдээлсэн зэрэг ач холбогдол бүхий баримтууд хэрэгт байхгүй, энэ талаар нотолж чадаагүй” гэж дүгнэж, зээлийн шимтгэлийг буцаан гаргуулж, нэхэмжлэгчид олгохоор шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, шийдвэрлэсэн.(14.9)

---o0o---

⁷ Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч хуулиар хориглоогүй буюу хуульд шууд заагаагүй эрх, үүргийг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлж болно.”

⁸ Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1-т “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.”

⁹ Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журмын 9 дүгээр зүйлийн 9.1-д “Зээл үүсгэх харилцаа, зээлийн өргөдөл, баримт бичгийн судалгаа хийх, шийдвэр гаргах, барьцаа хөрөнгийн үнэлгээ, тайлан, зээлийн түүхийн судалгаа, шуудан холбоо, нэмэлт судалгаа, хяналт, шалгалт, хугацаа сунгасны шимтгэл гэсэн нийт 8 зардлыг шингээж, шимтгэл нь зээлийн дүнгийн 1 хувиас хэтрэхгүй байна.”